



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 118 дугаар тогтоол, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл"-ийн хүрээнд бий болсон 3 нэрийн нийт 661,979,639.34 (зургаан зуун жаран нэгэн сая есөн зуун далан есөн мянга зургаан зуун гучин есөн төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, "Дарханы дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Дарханы дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Гантуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Барилга, байгууламжийн доорх газрыг "Дарханы дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн нэр дээр баталгаажуулах арга хэмжээ авах,

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001534

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
1/2 дугаар тогтоолын хавсралт



**"ДАРХАН ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Хөрөнгийн нэр | Улсын комиссын дүгнэлт | Гүйцэтгэгч байгууллага | Балансын үнэ (төгрөг) |
|-----------------|--|------------------------|--------------------------|--|
| 1 | Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багт Дулааны насос станцын тоног төхөөрөмж | №2018-01/48 | "Хүрд" ХК | 355,253,748.34 |
| 2 | Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багт Дулааны насос станцын хаалттай дэд өртөөний цахилгаан хангамж байгууламж | №2018-01/48-1 | | 109,746,076.19 |
| 3 | Дархан хотын дулааны насос станцын №3-ын барилга | №2018-01/48-2 | "Дархан есөн ундраа" ХХК | 196,979,814.81 |
| НИЙТ ДҮН | | | | 661,979,639.34 (зургаан зуун жаран нэгэн сая есөн зуун далан есөн мянга зургаан зуун гучин есөн төгрөг гучин дөрвөн мөнгө) |